



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 12 сарын 28 өдөр

Дугаар 757

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Стандарт хэмжил зүйн газрын харьяа Өвөрхангай аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 14,680,000.00 (арван дөрвөн сая зургаан зуун наян мянга) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан биет бус хөрөнгө (газар эзэмших эрх)-ийг Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвд балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Өвөрхангай аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга Г.Мөнхтөр, Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал Э.Хүдэрчулуун нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

13201704

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын
2020 оны 12 дугаар сарын 28 өдрийн
757 дугаар тогтоолын хавсралт

**Өвөрхангай аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн үндсэн хөрөнгөд
Өвөрхангай аймгийн Бүсийн оношилгоолны төвд балансаас балансад
шилжүүлэх хөрөнгө**

Д/д	Үндсэн хөрөнгийн нэр, байршил	Ашиглалтад орсон он	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Балансын үнэ (төгрөг)
1	Биет бус хөрөнгө, газар эзэмших эрх (Өвөрхангай аймаг, Арвайхээр, 13-р баг)	2018	м2	734	14,680,000.00
	Нийт дүн				14,680,000.00 (арван дөрвөн сая зургаан зуун наян мянга)